

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Даваахүү	Дугаар	L340
Оршин суугаа аймаг	Дундговь аймаг	Оршин суугаа сум	Адаацаг сум
Төрсөн газар	Адаацаг сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Шинэ шавийн хурал, Зуутын хийд, Тавин жас, Хорин хурал	Сүм хийдийн дугаар	ДУАЦ 031, ДУАЦ 026, ДУАЦ 030, ДУАЦ 028
Одоогийн сүм хийд	Дашчойнхорлин	Сүм хийдийн дугаар	ДУАЦ 029
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-рсарын 6	Ярилцлага авсан хүн	Жужа



Дундговь аймгийн Адаацаг сумын Тавин ламын жас, Хорин, Зуутын жас, Шинэ шавийн хийд, Дашчойнхорлин
 Жужа: Тэгээд энэ хийд хэдэн онд байгуулагдсан бэ?
 Даваахүү: Анх 1995 онд баригдаж, ерэн зургаан онд нээлтээ хийсэн. Яг анхны хурлыг бол 1990 онд хийсэн. Энэ үед гэрт байсан юм. За манай суманд байсан Тавин ламын жас гэж тэр хурлыг л одоо сэргээсэн юм даа.
 Жужа: Яг одоо санаачилж сэргээж үүсгэсэн хүмүүс нь хэн бэ?
 Даваахүү: Базар гэсгүй, Чүлтэм лам гэж хоёр өвгөн гол үүрэг гүйцэтгэсэн.
 Жужа: Энэ хоёр хүн хоёулаа Тавин ламын жасд сууж байсан лам хүмүүс үү?
 Даваахүү: За нэг нь, тийм ээ тийм хоёулаа манай энэ нутгийн л хүмүүс.
 Жужа: Танай хийдийн анхны хамба ямар хүн байсан бэ?
 Даваахүү: Лувсанбалдан гэж манай багш өвгөн байсан юм даа.
 Жужа: ерэн онд хэдэн лам байсан бэ?

Энэхүү нар дурдсан хүний амьтан ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагын хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Даваахүү: Үгүй ээ, нэлээн хэдэн лам байсан. Настай лам нар нэлээд байсан. Би нарийн мэдэхгүй юм.
 Жужа: Арав үү хорь үү барагцаа байна үү?
 Даваахүү: Үгүй ээ, хорь ер нь гучаад лам байсан байх.
 Жужа: Одоо хэдэн ламтай вэ?
 Даваахүү: Одоо нэг, 26...24 ламтай.
 Жужа: Одоо өвгөн лам нар хэд байна?
 Даваахүү: Таван өвгөн лам байна.
 Жужа: Нэрлэж болох үү?
 Даваахүү: Хамгийн ахмад нь Чүлтэм гуай, тэгээд Ёндонпэрэнлэй гуай, Гунгаа гуай, Хадзам, Ваанчиг гуай зэргийн настай лам нар байна аа.
 Жужа: Энэ бүгдээрээ энэ Тавин жасд байсан үү, Адаацагийн хүмүүс үү?
 Даваахүү: Манай энэ хавийг ерөнхийд нь Шинэ шавь гэдэг юм. За тэгээд дотроо Хорин хурал, Зуутын хийд, Тавин хурал гэж одоо энэ гурваас бүрддэг. Энэ гурвыг ах дүү гурван хурал хийд гэж ард түмэн ярьдаг юм. Эндхийн л хүмүүс л дээ. Одоо энэ Тавин жасын хурлын туурь яг энд байгаа.
 Жужа: Одоо 24 лам байна гэсэн. Хамба ламтай юу?
 Даваахүү: Хамба лам гэж үгүй. Ловон лам, гэсгүй, их бага уназд гэсэн тушаалтай лам нар байдаг.
 Жужа: Ловон нь ямар хүн байна?
 Даваахүү: Ловон нь Лхагва гэж хүн бий.
 Жужа: Хурлаа одоо өдөр болгон хурах үү?
 Даваахүү: За байнга өдөр бүхэн цогчин хурдаг.
 Жужа: Жил сарын онцгой дүйчэн өдрүүдэд ямар хурлууд хурдаг вэ?
 Даваахүү: Шинийн найманд манал, хажидын чог, дэмчигийн цог гээд олон цог хурна. Шинийн арван дөрвөнд ерөөл, магтаал, шинийн хорин есөнд хангал, чойжин хурдаг. Намрын эхэн сарын шинийн гурванд майдар эргэдэг. Хаврын эхэн сарын шинийн нэгнээс арван таванд ерөөл магтаал, зуны эхэн сард ганжуур эргэдэг.
 Жужа: Хайлан хурдаг үү?
 Даваахүү: Энэ урд Чойрын хийдийг байхад хайлан хурдаг байсан. Одоо хурахаа байсан.
 Жужа: Танай лам нарын дотор гэлэн сахилтай хүн бий юу?
 Даваахүү: Гэлэн сахилтай хүн байхгүй, харин гэцэл сахилтай лам бий.
 Жужа: Энэ гурван суварга хэзээ хэн ямар учиртай босгосон юм бэ?
 Даваахүү: За энэ хамгийн цаад талын суваргыг энэ хийдийн нээлтэнд зориулж 1997 онд сүсэгтэн олон босгосон юм. Дунд талын суваргыг 2001 онд манай тэр их лам миний багш Лувсанбалдан гэдэг хүний үр хүүхдүүд нь босгосон юм. Энэ наад талын суваргыг 2006 онд ноднин Базар гэдэг хүний ах дүү нар босгосон юм.
 Жужа: Зоч лам луйжин тавьдаг лам нар бий юу?
 Даваахүү: Эрдэнэбат гэж лам, одоо дэд лам гэдэг юм үү.

Энэхүү нар дурдсан хүний амьтан ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагын хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Энэ сүм хийдүүдтэйгээ холбоотой байдаг үү?
 Даваахүү: Өө холбоотой байдаг. Аймгаас бид нар лам авчирна, хамбыг нь авчирна. Хамтарч ном уншина.
 Жужа: Хийдийн товч танилцуулга бий юу?
 Даваахүү: Өө байдаг юм, байдаг юм. Манай бичээч лам дээр байдаг юм. Энд гаргаж тавиагүй байна.
 Жужа: Зуутын хурал дээр хоёр шинэ дуган байна гэж харлаа. Тэнд одоо лам нар байнга байдаг үү?
 Даваахүү: Үгүй, үгүй. Тэр хоёр дуган чинь яг тэр хурлын хуучны хоёр дуган нь байж байгаа юм. Манай эндхийн майдартай давцаж тэнд лам нар хотоос ирж, Дашчоймболос ирж сахиус тахидаг. Тэр Зуутын хурлын гэсгүй нь Дашчоймбол хийдийн цорж лам Чүлтэм гэдэг байх аа, тийм хүн байдаг. Яг л Зуутын хүн л дээ. Тэгээд хотоос лам нартай ирж хурдаг юм.
 Жужа: Тэнд ерэн оноос хойш лам нар сууж байсан үү?
 Даваахүү: Уг нь эхлээд сууж байсан юм. Энэ Шинэ шавь дээр хүртэл хийд байсан юм ш дээ. Одоо нэг суварга байна үү, тэнд уулын оройн өвгөн Балжир гэж өвгөн сууж байсан юм. Тэдний үр хүүхдүүд нэг дуган босгосон байсан юм. Тэгээд сүүлд нь буулгаад аймаг руу аваад явчихсан. Тэнд бас хуралтай л байсан юм. Одоо нэг суварга л босгосон. Сахиус энэ тэр нь гэрт нь байдаг байх аа, тэр Балжир гэдэг хөгшнийд.
 Жужа: Танай хийдэд өмнөх хийдүүдээс уламжилж ирсэн бурхан шүтээн, судар ном бий юу?
 Даваахүү: За ховор доо. Манай тэр багш өвгөн уран хүн байсан юм. Энэ Дэлгэрийн чойроос майдар бурханбусад энэ бурхны зарим нэг чимэглэлүүдийг хуулбарлаж авчтрч өгсөн юм аа.
 Жужа: Ер нь энэ Адаацагийн хуучны хурал хийдүүдэд ямар нэгэн цам байсан үү?
 Даваахүү: Аа манай энд цам ер нь байгаагүй юм гэнэ лээ. Чойрт, энэ Зуутаг л байсан юм гэнэ лээ.
 Жужа: За баярлалаа.

Энэхүү нар дурдсан хүний амьтан ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагын хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон